

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 7543 дугаарт бүртгэв.*

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 1 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар А/11

Улаанбаатар
хот

ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИНГ ТОГТООХ ТУХАЙ

Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1,5.3, 5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүн амын амьжиргааны доод түвшний 2026 онд мөрдөх хэмжээг тогтоож, хавсралтаар баталсугай.

2.Шинэчлэн баталсан Хүн амын амьжиргааны доод түвшинг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, нийтэд мэдээлэхийг Тамгын газар (Б.Лхагва)-т даалгасугай.

Б.БАТДАВАА

*Үндэсний статистикийн хорооны даргын
2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн
А/11 дүгээр тушаалын хавсралт*

ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮСЭЭР

Бүс	Бүсэд хамаарах аймаг	Амьжиргааны доод түвшин, төгрөг
1. Баруун	Баян-Өлгий Говь-Алтай Завхан Увс Ховд	538,700
2. Хангай	Архангай Баянхонгор Булган Өвөрхангай Хөвсгөл Орхон	526,200
3. Төв	Говьсүмбэр Дорноговь Дундговь Өмнөговь Сэлэнгэ Төв Дархан-Уул	522,300
4. Зүүн	Дорнод Сүхбаатар Хэнтий	519,200
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	543,700

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 2 дугаар сарын 13-ны өдөр хүлээн авсан.*

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар А/273

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 77 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.3ам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн А/226 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам”-ын 2 дугаар бүлэгт дор дурдсан заалт нэмсүгэй.

1.1. 2.13.Засгийн газрын 2016 оны 103 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасан хэмжээгээр “Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2025 стандартын 5.2-т заасан бодит жинтэй уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэж буй ачаа тээврийн хэрэгслээс олон улс, улсын чанартай авто зам дайран өнгөрч байгаа аймаг тус бүрт 1 удаа авто зам ашигласны төлбөр авна.

1.2. 2.14.Журмын 2.13-т заасан тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авахдаа урьдчилан төлөх болон төлбөр авах цэгээр нэвтрэх үед төлүүлэх арга хэмжээ авна.

1.3. 2.15.Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэж ачаагаа буулгасан тээврийн хэрэгсэл буцаад төлбөр авах цэгээр гарахдаа Засгийн газрын 2016 оны 103 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан хэмжээгээр төлбөр төлнө.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Авто замын бодлого зохицуулалтын газар /Ч.Сугармаа/, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Д.Оюунболд/-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Х.Оюунтуяа/-т даалгасугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 12 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар А/241

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Өрийн удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Өрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах, төвлөрүүлэх, өр төлбөрийг бүртгэх, тайлагнах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, мэдээ, тайлангийн маягыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн бодлогын газар /С.Тулга/, Төрийн сангийн газар /Б.Цогбадрах/-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Сангийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 300 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

